



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 16,426,351,304.00 (арван зургаан тэрбум дөрвөн зуун хорин зургаан сая гурван зуун тавин нэгэн мянга гурван зуун дөрөв) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Өмнөговь, Баянхонгор, Хэнтий, Увс, Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, эзэмшигчийг тогтоох, бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Р.Далан

Д.НАРАНГЭРЭЛ

132000250

4-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 02-дугаар сарын 20-ны/ний өдрийн
дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРВСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСАЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Өмнөговь аймгийн Манлай сум дахь Эрүүл мэндийн Төвийн барилга. (Өмнөговь аймгийн Манлай сум дахь Эрүүл мэндийн Төвийн өөрийн эзэмшилийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, 15 ортой барилга, дунд, төвөгшилтэй, зоорыгүй, 2 давхар. А блок тэнхтэгээрээ 30.0м*21.0м, Б блок 6.0м*16.5м (Шарил хадгалах байр 7.0м*6.0м, хог тур хадгалах байр 4.0м*6.0м, Авто зогсоол, явган хүний зам, гадна цахилгаан, инженер, холбооны шулагам, хашаа, сүүдрэвч, гэрэлтүүлэг, гадна тохижилт)	1,919,900,000.00	2024.10.21	У-2024/109	Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газар (Өмнөговь аймгийн Манлай сум дахь Эрүүл мэндийн төв)
2	Баянхонгор аймгийн Нэгдсан эмнэлгийн өргөтгөлийн барилга. (Баянхонгор аймгийн өөрийн эзэмшилийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, өргөтгөлийн барилга, зоорьтой, 3 давхар, тэнхлэгээрээ 24.0м*36.0м, (гадна зам талбай, тоног төхөрөмжүүд, хүзүүчийн барилга, дотор гэрэлтүүлэг, цахилгаан шат)	9,490,119,197.00	2024.12.13	2024/20	Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар, (Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг)
3	Хэнтий аймгийн Дархан сум дахь Эрүүл мэндийн төвийн барилга. (Хэнтий аймгийн Дархан сум, Эрүүл мэндийн төвийн өөрийн эзэмшилийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 2.5м*2.35м (авто зогсоол, явган хүний зам, сүүдрэвч, гэрэлтүүлэг, гадна тохижилт)	951,132,107.00	2023.12.15	БУА-103/2023	Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар, (Хэнтий аймгийн Дархан сум Эрүүл мэндийн төв.)

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
4	Үвс аймгийн Наранбулаг сүм дахь Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга. (Үвс аймгийн Наранбулаг сум Эрүүл мэндийн төвийн өзэмшигийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд төвөгшилтэй, өргөтгөлийн барилга, 10 ортой давхар, зоорлыг, тэнхлэгээрээ 30.0*21.0M, 16.0*6.0M, (шарил хадгалах байр, бохир усны шугам цоног, гадна Цахилгаан 0.4кв шугам, шугам супжээ, холбооны шилэн кабельв, цэвэрлэх байгууламж, авто болон явган зам, гадна тохижилт, 35/0.4кв-ын трансформатор, гэрэлтүүлэг) дээр)	994,600,000.00	2022.12.15	57	Үвс аймгийн Орон нутгийн өмчийн газар, (Үвс аймгийн Наранбулаг сум)
5	Завхан аймгийн Яруу сум дахь Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга. Завхан аймгийн Яруу сум Эрүүл мэндийн төвийн өөрийн эзэмшигийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд төвөгшилтэй, өргөтгөлийн барилга, 15 ортой, 2 давхар, зоорлыг, тэнхлэгээрээ 30.0*21.0M, 16.0*6.0M, (шарил хадгалах байр, бохир усны шугам цоног, гадна Цахилгаан 0.4кв шугам, шугам супжээ, холбооны шилэн кабельв, цэвэрлэх байгууламж, авто болон явган зам, гадна тохижилт, 35/0.4кв-ын трансформатор, гэрэлтүүлэг)	3,070,600,000.00	2024.12.05	ББКД-81-0004/24	Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар, (Завхан аймгийн Яруу сум, Эрүүл мэндийн төв)
			16,426,351,304.00			(арван зургаан тэрбум дөрвөн зуун хорин зургаан сая гурван зуун тавин нэгэн мянга гурван зуун дөрөв)
		НИЙТ ДҮН				